

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар Б/397

Улаанбаатар хот

Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан "Жендэрийн үндэсний хорооны дүрэм"-ийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах "Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгууллагын эрхлэх асуудалд хамаарах арга хэмжээг тусган хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Жендэрийн орон тооны бус дэд салбар зөвлөл (Н.Оюунбилэг)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилгын хөгжлийн төвийн захирлын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн Б/34 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Т.ПҮРЭВХАТАН



Барилгын хөгжлийн төвийн захирлын
2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
6/307 дугаар тушаалын хавсралт

ЖЕНДЭРИЙН ОРОН ТООНЫ БУС ДЭД САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дэд салбар зөвлөлийн дарга:

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Гишүүд:

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Сургалт, судалгаа мэдээллийн хэлтсийн
дарга

Зураг төслийн хяналтын хэлтсийн ахлах
мэргэжилтэн

__оОо__